



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 24 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 24142

Улаанбаатар хот

**Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр батлах тухай**

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулагчдад Компанийн талаарх үнэн зөв мэдээ мэдээллийг тогтмол хүргэх, тэдний оролцоог сайжруулах зорилгоор Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7.32.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол Даатгал” ХК-ийн “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Од/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Т.Цацрал/ нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.



Буухиа даатгал: +976 7010-1990  
Даатгалын лавлах: +976 1800-1990



www.mongoldaatgal.mn  
insurance@mongoldaatgal.mn





# MONGOL DAATGAL

## MONGOL DAATGAL JOINT STOCK COMPANY RESOLUTION OF THE BOARD OF DIRECTORS

Date: 25 / Dec / 20 24

No 24142

Ulaanbaatar City

### Approval of the Investor Relations Program

In order to ensure the implementation of the Corporate Governance Code, provide investors with accurate and timely information about the Company, and enhance their engagement, based on Article 76.1.13 of the Company Law and Article 7.32.11 of the Company's Charter, it is hereby **RESOLVED**:

1. The "Investor Relations Program" of "Mongol Daatgal" JSC shall be approved in accordance with Annex No.01.
2. To assign the Chief Executive Officer (Od M.) and the Secretary of the Board of Directors (Tsatsral T.) to ensure the implementation of this program.
3. To assign the Board of Directors to monitor the implementation of this resolution.

CHAIRMAN



GROMOV S.B.



Call center: +976 1800-1990



insurance@mongolmaatgal.mn



www.mongolmaatgal.mn



“Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/42 тоот  
тогтоолын Нэгдүгээр хавсралт



**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН  
“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР”**



## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	1
ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ .....	1
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ.....	2
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА .....	2
ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ .....	2



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь “Монгол Даатгал” ХК-ийн хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, Компанийн засаглал, стратегийн хэрэгжилт, санхүүгийн гүйцэтгэл, шаардлагатай бусад мэдээллийг хүргэх, мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Компани нь энэхүү “Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхийг зорьж ажиллана. Үүнд:

1.2.1. Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээ мэдээллээр тухай бүр хангах;

1.2.2. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;

1.2.3. Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн цахим сувгийг бий болгох замаар ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэн болон Компанийн засаглалыг сайжруулах;

1.2.4. Хөрөнгө оруулагчдыг Компанитай харилцах оролцоог нэмэгдүүлэх.

### ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дараах мэдээллийг Компанийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр хүргэнэ.

2.1.1. Жилийн болон хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;

2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл;

2.1.4. Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;

2.1.5. Хөрөнгө оруулагчдын ирүүлсэн санал хүсэлт, гомдол болон шийдвэрлэсэн байдал;

2.1.6. Компанийн шаардлагатай бусад мэдээлэл.

2.2. Компани нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.

2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр Компанийн санхүүгийн гүйцэтгэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;

2.2.2. Цахимаар болон биечлэн санал авах, асуулга зохион байгуулах;

2.2.3. Цахимаар болон биечлэн мэдээлэл хүргэх, солилцох;

2.2.4. Бусад арга хэрэгслээр мэдээлэл солилцох.



## **ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ**

- 3.1. Хөрөнгө оруулагч нь санал хүсэлт, гомдлыг [info@mongoldaatgal.mn](mailto:info@mongoldaatgal.mn) хаяг, Компанийн цахим хаяг **Mongoldaatgal.mn** хаягаар дамжуулан цахимаар гаргах, 94001934 тоот утсанд хандан амаар гаргах, эсхүл өөрийн биеэр бичгээр хүргүүлнэ.
- 3.2. Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг тэр даруй ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нөхцөл байдлыг тодруулж, Компанийн холбогдох албан тушаалтантай хамтран шийдвэрлэнэ.
- 3.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, Компанийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэх үүрэгтэй.
- 3.4. Компани нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Хөрөнгө оруулагчийн и-мэйл хаягт, түүний цахим хаягт, түүнтэй утсаар холбогдон хүргүүлэх эсвэл бичгээр хүргүүлнэ.

## **ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА**

- 4.1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнан ажиллана.
- 4.2. Энэхүү “Хөтөлбөр”-ийг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх бөгөөд Компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
- 4.3. Компани болон Хөрөнгө оруулагчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв эс чадвал маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## **ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 5.1. Энэхүү бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр өөрчилж, сайжруулж, хүчингүй болгож болно.
- 5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажиллана.

---oOOOo---





2032317 44 9019129961

## **“INVESTOR RELATIONS PROGRAM” OF “MONGOL DAATGAL” JSC**



## CONTENTS

ONE. COMMON GROUNDS .....	1
TWO. COMMUNICATION WITH INVESTORS .....	1
THREE. PROPOSALS FROM INVESTORS: RECEIVING AND RESOLVING COMPLAINTS.....	2
FOUR. RESPONSIBILITY .....	2
FIVE. REVISIONS, IMPROVEMENTS, AND CHANGES .....	2



## **ONE. COMMON GROUNDS**

1.1. The purpose of this "Investor Relations Program" (hereinafter referred to as the "Program") is to inform the investors of "Mongol Daatgal" JSC about events that may affect the Company's operations, governance, strategic implementation, financial performance, and other relevant information, and to regulate the exchange of such information.

1.2. The Company aims to achieve the following outcomes through the implementation of this "Program":

1.2.1. Enhance the transparency and openness of the Company's financial and non-financial reporting to meet international standards, ensuring investors have access to accurate information at all times;

1.2.2. Protect the interests of investors and strengthen mutual trust;

1.2.3. Attract future investors, improve business value, and enhance Company governance by establishing an electronic communication channel for investors that adheres to international corporate governance principles;

1.2.4. Increase investor participation in communication with the Company.

## **TWO. COMMUNICATION WITH INVESTORS**

2.1. The Company will periodically provide investors with the following information through its website and social media channels:

2.1.1. Annual and semi-annual financial and operational reports;

2.1.2. Announcements and materials related to shareholders' meetings;

2.1.3. Information on business and financial developments that may impact investor decision-making;

2.1.4. Market research and expert opinions;

2.1.5. Feedback and complaints submitted by investors, along with their resolutions;

2.1.6. Any other information required by the Company.

2.2. The Company engages with investors through the following methods:

2.2.1. During shareholders' meetings, discussions are held on the Company's financial performance, reports from the Board of Directors, the Executive Director, and the external auditor, along with the proposed resolutions. Opinions are gathered, and inquiries are addressed;

2.2.2. Conducting online and in-person polls and surveys;

2.2.3. Delivering and exchanging information both electronically and in person;

2.2.4. Sharing information through other available means.



### **THREE. PROPOSALS FROM INVESTORS: RECEIVING AND RESOLVING COMPLAINTS**

- 3.1. Investors may submit comments and complaints electronically to info@mongoldaatgal.mn, through the Company's website Mongoldaatgal.mn, and via phone at 94001934, or in writing in person.
- 3.2. Feedback and complaints submitted by investors will be promptly forwarded to the Secretary of the Board of Directors. The Secretary, in collaboration with the relevant Company officials, will investigate and address the situation.
- 3.3. The Secretary of the Board of Directors is responsible for handling suggestions and complaints submitted by investors in accordance with the relevant laws and regulations of Mongolia, the regulations approved by competent authorities, and the Company's internal rules and policies.
- 3.4. The Company will inform the investor of the resolution of their feedback and complaints via email, phone, or in writing, using the contact details provided by the investor.

### **FOUR. RESPONSIBILITY**

- 4.1. The Secretary of the Company's Board of Directors shall regularly report to the Board on the resolution of suggestions and complaints submitted by investors.
- 4.2. Any person who violates this "Program" will be held liable as stipulated by the Company Law and other relevant laws, and will be responsible for any damage caused to the Company.
- 4.3. In the event of a dispute between the Company and an investor, both parties will first attempt to resolve it amicably. If an amicable resolution is not possible, the dispute will be settled by the courts of Mongolia.

### **FIVE. REVISIONS, IMPROVEMENTS, AND CHANGES**

- 5.1. This policy document may be amended, improved, or revoked by a decision of the Board of Directors.
- 5.2. The Board of Directors will oversee the implementation of this Program.

---oOOOo---